



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2012 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Бүртгэгчийн эрх цуцлах тухай

“Монгол Улсын Засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2003 оны 3 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголиан маритайм энд шип регистрейшн бюро” ХХК-ийн Монголын хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх эрхийг 2012 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн цуцалсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны “Бүртгэгч томилох тухай” 264 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. “Монголиан маритайм энд шип регистрейшн бюро” ХХК-тай байгуулсан гэрээг цуцалж, цуцалсан тухай мэдэгдлийг холбогдох байгууллагад хүргүүлэхийг Далайн захиргаа /Х.Энхбаатар/-нд үүрэг болгосугай.



А. ГАНСҮХ